| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 488,300.00 | 468,208.00 | 385,700.00 | 370,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,724,900.00 | 7,586,500.00 | 8,674,900.00 | 6,793,020.00 |

Асгат сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|-------------|--|-----------------------|----------------------|----------------------|----------------------|
| 2105 | Нормативт зардал | 68,308,600.00 | 51,334,564.00 | 82,609,100.00 | 77,732,857.78 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 12,061,700.00 | 12,061,700.00 | 28,355,400.00 | 26,189,307.78 |
| 210502 | Хоол, хүнс | 51,101,900.00 | 35,925,734.00 | 48,608,700.00 | 46,898,550.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,145,000.00 | 3,347,130.00 | 5,645,000.00 | 4,645,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 17,880,400.00 | 13,526,142.00 | 12,080,700.00 | 10,844,980.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,871,100.00 | 7,688,800.00 | 6,089,500.00 | 4,853,780.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 191,800.00 | 0.00 | 191,800.00 | 191,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,817,500.00 | 5,837,342.00 | 5,799,400.00 | 5,799,400.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,754,700.00 | 5,751,700.00 | 9,904,700.00 | 9,897,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,754,700.00 | 5,751,700.00 | 9,904,700.00 | 9,897,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 16,438,400.00 | 15,201,438.00 | 11,729,800.00 | 10,270,806.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,720,500.00 | 5,820,300.00 | 6,603,300.00 | 6,602,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 642,100.00 | 642,100.00 | 3,253,600.00 | 1,832,300.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 539,100.00 | 374,973.00 | 539,100.00 | 539,040.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 295,700.00 | 187,093.00 | 295,700.00 | 295,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,600.00 | 88,600.00 | 43,400.00 | 43,379.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,903,400.00 | 7,901,400.00 | 203,400.00 | 203,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 188,300.00 | 141,972.00 | 296,300.00 | 296,287.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 60,700.00 | 45,000.00 | 45,000.00 | 8,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 0.00 | 0.00 | 450,000.00 | 450,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,560,700.00 | 18,905,500.00 | 45,644,500.00 | 45,614,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,409,200.00 | 8,852,000.00 | 30,978,000.00 | 30,948,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,151,500.00 | 10,053,500.00 | 14,666,500.00 | 14,666,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9,815,000.00 | 9,829,124.00 | 12,325,200.00 | 12,325,200.00 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 0.00 | 14,124.00 | 0.00 | 0.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0.00 | 14,124.00 | 0.00 | 0.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 9,815,000.00 | 9,815,000.00 | 12,325,200.00 | 12,325,200.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 9,315,000.00 | 9,315,000.00 | 11,315,200.00 | 11,315,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 500,000.00 | 1,010,000.00 | 1,010,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 84,318,500.00 | 66,895,000.00 | 54,747,400.00 | 36,960,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 84,318,500.00 | 66,895,000.00 | 54,747,400.00 | 36,960,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 84,318,500.00 | 66,895,000.00 | 54,747,400.00 | 36,960,000.00 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 120,000,000.00 | 65,617,894.00 | 60,000,000.00 | 15,761,210.00 |

Асгат сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|---------------|---|------------------|----------------------|------------------|------------------|
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 120,000,000.00 | 65,617,894.00 | 60,000,000.00 | 15,761,210.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,854,862,100.00 | 1,700,634,214.21 | 1,862,259,100.00 | 1,851,371,200.43 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,051,952,100.00 | 1,026,444,631.60 | 1,111,712,700.00 | 1,102,412,607.35 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,051,952,100.00 | 1,026,444,631.60 | 1,111,712,700.00 | 1,102,412,607.35 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 613,115,200.00 | 625,507,762.61 | 629,587,100.00 | 661,925,471.08 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 569,795,500.00 | 582,246,360.61 | 592,245,500.00 | 624,584,012.08 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 43,319,700.00 | 43,261,402.00 | 37,341,600.00 | 37,341,459.00 |
| 1340 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 9,798,300.00 | 1,217,950.00 | 9,798,300.00 | 519,120.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 9,798,300.00 | 1,217,950.00 | 9,798,300.00 | 519,120.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 179,996,500.00 | 47,463,870.00 | 111,161,000.00 | 86,514,002.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 96,696,800.00 | 47,463,870.00 | 54,891,500.00 | 86,514,002.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 83,299,700.00 | 0.00 | 56,269,500.00 | 0.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 64,301,922.58 | 0.00 | 22,514,300.58 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 22,514,300.58 | 0.00 | 94,097,800.66 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | 29.00 | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 6.00 | 6.00 | 6.00 | 6.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 6.00 | 6.00 | 6.00 | 6.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 98.00 | 98.00 | 98.00 | 98.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 11.00 | 11.00 | 11.00 | 11.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 54.00 | 54.00 | 53.00 | 53.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 30.00 | 30.00 | 31.00 | 31.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 3.00 | 3.00 | 3.00 | 3.00 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 350.00 | 350.00 | 350.00 | 350.00 |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | 240.00 | 240.00 | 240.00 | 240.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 240.00 | 240.00 | 240.00 | 240.00 |
| 631 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА | 110.00 | 110.00 | 110.00 | 110.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 110.00 | 110.00 | 110.00 | 110.00 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 98.00 | 98.00 | 98.00 | 98.00 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 8.00 | 8.00 | 8.00 | 8.00 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 55.00 | 55.00 | 55.00 | 55.00 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 5.00 | 5.00 | 5.00 | 5.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 14.00 | 14.00 | 14.00 | 14.00 |

| | | | | | |
|--------|--|------|------|------|------|
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 7.00 | 7.00 | 7.00 | 7.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 3.00 | 3.00 | 3.00 | 3.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 6.00 | 6.00 | 6.00 | 6.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | /төгрөгөөр/ | |
|-------------|--|-------------|----------------------|
| | | Өмнөх он | Гүйцэтгэл |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 66,204,288.32 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 66,204,288.32 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 19,502,770.32 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | - | 4,328,788.00 |
| 210104 | Урамшуулал | - | 4,328,788.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | - | 2,457,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 2,457,500.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | - | 2,373,140.32 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 1,079,887.32 |
| 210302 | Түлш, халаалт | - | 1,293,253.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 1,958,978.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 306,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 1,652,778.00 |
| 2105 | Нормативт зардал | - | 3,258,259.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 2,622,218.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 636,041.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 1,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 819,383.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 819,383.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 3,306,722.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 3,306,722.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 46,701,518.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 46,701,518.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 22,901,518.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 23,800,000.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 2,054,305.41 |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | - | |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | - | 2,054,305.41 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 68,258,593.73 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 68,258,593.73 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 67,858,593.73 |

| | | | |
|-----------|--|--|------------|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 400,000.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 360,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 360,000.00 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Асгат сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитор Г.Чулуунбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Асгат сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 1/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл:

“Иргэд олон нийтийн санал санаачлагад тулгуурлан төрийн үйлчилгээг иргэн бүрт шуурхай, жигд хүртээмжтэй, үнэнч шударгаар хүргэж, оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх, чадварлаг үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Үүнд:

- Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдлэн хөгжүүлнэ;
- Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ;
- Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх;
- Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлнэ;
- Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, амьдралын түвшинг дээшлүүлнэ;
- Төсөв санхүү, хөрөнгийн бодлогыг зөв тодорхойлон эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлнэ;
- Хүний хөгжил, эрхийг хангасан, ажлын байрыг нэмэгдүүлсэн, иргэн төвтэй төрийн үйлчилгээг нэвтрүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг өргөжүүлэн шударга ёсны тогтолцоог төлөвшүүлнэ;
- Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана;
- Мал аж ахуй, газар тариаланг хослуулан хөгжүүлнэ;
- Дэд бүтцийг сайжруулна;
- Байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сумын засаг даргын дэргэд дотоод хяналтын нэгжийг байгуулсан байна. Энэхүү хяналтын нэгж нь ТШЗ-ийн үйл ажиллагаанд хяналтыг хангалттай хэмжээнд хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Асгат сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны мөнгөн хөрөнгийн нийт орлого 2,567.3 сая төгрөгийн 1.5 хувь буюу 38.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 28.9 сая төгрөгөөр тус тус тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 140.79 сая төгрөг болж өмнөх оноос 80.79 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн 75.80 сая төгрөг нь СХС-ийн, 17.70 сая төгрөг нь ОНХС-ийн, 0.24 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн, 47.05 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл байна.

Авлага

Авлагын дансны үлдэгдэл 117.74 сая төгрөг болж өмнөх оноос 60.76 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь холбогдох байгууллагуудын авлагын барагдуулалттай холбоотой байна.
/төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------------------------|-----------------------|-----------------------|
| Сум хөгжүүлэх сан | 177,186,435.58 | 111,798,373.58 |
| Ерөнхий боловсролын сургууль | 497,280.23 | 3,759,406.00 |
| Эрүүл мэндийн төв | - | 1,345,733.00 |
| Соёлын төв | 587,500.00 | 111,536.66 |
| Засаг даргын тамгын газар | 132,881.00 | 730,000.00 |
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 99,467.00 | - |
| Нийт дүн | 178,503,563.81 | 117,745,049.24 |

Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 92.32 сая төгрөг болж өмнөх оноос 1.10 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь Эрүүл мэндийн төвд Ковид-19 цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,178.76 сая төгрөг болж өмнөх оноос 29.66 сая төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардал хасагдсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр

Өглөгийн дансны үлдэгдэл 4.07 сая төгрөг болж өмнөх оноос 5.65 сая төгрөгөөр буурсан байна.

/төгрөгөөр/

| регистр | Байгууллагын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|------------------------------|---------------------|---------------------|
| 9036776 | Ерөнхий боловсролын сургууль | 8,132,158.00 | 0.00 |
| 9036784 | Эрүүл мэндийн төв | 746,394.00 | 3,776,637.40 |
| 9036806 | Соёлын төв | 587,500.00 | 263,913.00 |
| 9036814 | Засаг даргын тамгын газар | 259,155.00 | 30,000.00 |
| Нийт | | 9,725,207.00 | 4,070,550.40 |

Цэвэр хөрөнгө

Цэвэр хөрөнгийн дүн 2,525.55 сая төгрөг болж өмнөх оноос 2.90 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Төсвийн шууд захирагчийн илрүүлэлт:

- Зочид буудал, халуун усны барилгыг дулаанд холбох ажлын гүйцэтгэлийн тайланг ирүүлээгүй, сумын Засаг даргаас томилсон комисс хэмжилт хийж хүлээж аваагүй;
- Ур чадварын нэмэгдэл илүү тооцож олгосон, цалингийн урьдчилгаа, актын төлбөрийг суутгаагүй, хүнсний материалын худалдан авалтын баримтыг хуурамчаар бүрдүүлэн, цэцэрлэгийн мөнгөн хөрөнгийг дутагдуулсан;

- *Ахмадын өргөө, Иргэний танимын засвар, сургуулийн камержуулалт, нөөцийн худгийн засвар, Эрүүл мэндийн төвд багаж нийлүүлэх зэрэг ажлууд гэрээт хугацаандаа хэрэгжээгүй байна;*
- *Тэтгэмж илүү тооцож олгосон;*
- *Батлагдсан орон тооноос 1 гэрээт ажилтан илүү ажиллуулсан;*
- *Ажилтнуудад ур чадварын нэмэгдлийг олгохдоо үр дүнгийн урамшуулал олгосон шалгуур үзүүлэлтээр дүгнэж олгосон, нийт 42.29 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.*

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг анх батлахдаа 1,983.81 сая төгрөгөөр тооцон төлөвлөж баталсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт тодотгол хийж 121.56 сая төгрөгөөр бууруулж, 1,862.25 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1,862.25 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,747.51 сая төгрөгийг урсгал зардалд, 54.74 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 60.00 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 1,111.71 сая төгрөгийг улсын төсвөөс, 592.24 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 9.79 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 37.34 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 54.89 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 56.28 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,102.41 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 624.58 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 0.51 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 37.34 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 86.53 сая төгрөг, нийт 1,851.37 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь 10.88 сая төгрөгийн санхүүжилт дутуу байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 86.51 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 31.62 сая төгрөгөөр давсан нь зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдсөнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,779.78 сая төгрөг буюу 95.6 хувьтай байгаа нь төсөвт санхүүжилт дутуу олгогдсон, эргэн төлөгдөх зээлийг төлөвлөсөн хэмжээгээр олгоогүй, ОНХС-ийн төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэгтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 0.53 сая төгрөгийг сумын төсөвт, 10.75 сая төгрөгийг аймгийн төсөвт, 0.00 сая төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 0.00 сая төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчаас 67.85 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 0.40 сая төгрөгийн, нийт 68.25 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 68.25 сая төгрөгийг бүрэн зарцуулж, 0.36 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд онцлон үзэх эрсдэлтэй асуудал тусгагдаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Аудитын хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлттэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 155 мэдээллээс, 148 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 1 мэдээллийг огт мэдээлээгүй, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Асгат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бусад мэдээлэлтэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн аудитаар нийт 50.29 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 8.00 сая төгрөгийн алдааг залруулж, 42.29 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.1 Залруулсан алдаа

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг нэгтгэхдээ мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгийн зардлын биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг дутуу тайлагнасан алдааг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй байна.

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд, шууд захирагчдын төрийн сангаар хийгдэж буй ажил гүйлгээнд хяналт тавиагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил байна. Тухайлбал: Ур чадварын нэмэгдэл илүү тооцож олгосон, цалингийн урьдчилгаа, актын төлбөрийг суутгаагүй, хүнсний материалын худалдан авалтын баримтыг хуурамчаар бүрдүүлэн, цэцэрлэгийн мөнгөн хөрөнгийг дутагдуулсан, тэтгэмж илүү тооцож олгосон, батлагдсан орон тооноос 1 гэрээт ажилтан илүү ажиллуулсан, ажилтнуудад ур чадварын нэмэгдлийг олгохдоо үр дүнгийн урамшуулал олгосон шалгуур үзүүлэлтээр дүгнэж олгосон зэрэг зөрчлүүд байна.

Энэ нь Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7.6. /хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх/, Засгийн Газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7 дугаар зүйлийн 7.13.7 /энэхүү журмын 7.8-д заасан анхан шатны баримт дутуу, иж бүрдэл болоогүй тохиолдолд/, 8 дугаар зүйлийн 8.4 /Төрийн сан төсвийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг холбогдох баримт, цахим хэлбэрээр шивсэн гүйлгээ, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнд багтаан төлбөрийг гүйцэтгэнэ. Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана/ гэсэн заалтууд, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдээдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсөв захирагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн Аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---------------------------------------|-------------------------------------|----------------------|---------------|-----------|---------------|---------------|--------------|-----------------|---------------|-----------|--------------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | ЗДТГ | 7 | 37.95 | 4 | 14.19 | - | 0.00 | - | 0.00 | 3 | 23.79 |
| 2 | Эрүүл мэндийн төв | 7 | 48.97 | 2 | 12.49 | 1 | 0.55 | 4 | 35.93 | - | 0.00 |
| 3 | Хүүхдийн цэцэрлэг | 8 | 165.07 | 3 | 25.28 | 2 | 6.30 | 3 | 133.48 | - | 0.00 |
| 4 | Соёлын төв | 3 | 1.43 | - | 0.00 | - | 0.00 | - | 0.00 | 3 | 1.43 |
| 5 | Ерөнхий боловсролын сургууль | 8 | 614.53 | 3 | 146.28 | 2 | 10.48 | 3 | 457.75 | - | 0.00 |
| 6 | Орон нутгийн хөгжлийн сан | 3 | 21.71 | - | 0.00 | - | 0.00 | - | 0.00 | 3 | 21.71 |
| 7 | Сум хөгжүүлэх сан | 1 | 1.60 | - | 0.00 | - | 0.00 | - | 0.00 | 1 | 1.60 |
| 8 | Төвлөрүүлэн захирагч | 7 | 50.29 | 1 | 8.00 | - | 0.00 | - | 0.00 | 6 | 42.29 |
| Дүн | | 44 | 941.55 | 13 | 206.24 | 5 | 17.33 | 10 | 627.16 | 16 | 90.82 |

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Г.ЧУЛУУНБААТАР

ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ДАГВАСҮРЭН

2022.03.25